## ҮНЭТ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН ЗЭРЭГЛЭЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ” ҮЗМЭРИЙН ЖАГСААЛТЫН ТӨСӨЛ

<table>
<tr><th colspan="9">ЧОЙЖИН ЛАМЫН СҮМ МУЗЕЙ</th></tr>
<tr><th>Д/д</th><th>Үзмэрийн нэр</th><th>Хувийн дугаар</th><th>Тоо ширхэг</th><th>Хэмжээ</th><th>УБМС-ийн дугаар RCH (прораммын)</th><th>Судлагдсан сурталчлагдсан байдал</th><th>Саналын үндэслэл</th><th>СӨҮТ-ийн санал</th></tr>
<tr><td>1</td><td>Жигжид</td><td>Г.42.113</td><td>1</td><td>Урт-92см,<br>Өргөн-65см<br>Хүрээ торго:<br>Урт-178 см<br>Өргөн-92см</td><td>1119ЧЛМ 00265</td><td rowspan="7">- “Mongolian Art”, Интерпрэсс ХХК, УБ, 2016 он.<br>- “Шүтээн зургийн урлаг”, Адмон принт ХХК, УБ, 2018 он.<br>- “Mongolian Art”, Интерпрэсс ХХК, УБ, 2016 он.<br>- “Шүтээн зураг” түр үзэсгэлэн, Чойжин ламын сүм музей, 2016 он.<br>- “Шүтээн зургийн урлаг”, Адмон принт ХХК, УБ 2021 он.<br>- “Mandala-secret tantric temple” Адмон принт ХХК, УБ, 2018 он.<br>- “Хот мандал-Нууц тарнийн сүм” гэрэл зургийн үзэсгэлэн, ХБНГУ-ын Берлин хотын Үндэсний номын сан, 2019 он<br>- “Хот мандал-Нууц тарнийн сүм” гэрэл зургийн үзэсгэлэн, Польш улсын Варшав</td><td rowspan="7">Чойжин ламын сүм музейд Монголын шүтээн урлахуй ухааны нэгэн дэг сургууль болох Их хүрээний сургуулийн даамал (удирдан гүйцэтгүүлэгч) Андуу нарын аймгийн зураач З.Хасгомбо, Тавхайбор, Тамжав нарын удирдлага дор Богдын хүрээний урчуудын бүтээн урласан олон бүтээл хадгалагддаг. Эдгээр бүтээлүүдийн нэг бол Балжинням гэлэнгийн цувралаар бүтээн урласан арван хангалын шүтээн зураг мөн. Монгол урлаачид эртний Энэтхэгийн “Гандхарын сургууль”-ийн дэг, урлахуйн онолыг Монгол зургийн ёс уламжлалд тулгуурлан хөгжүүлж ирсэн түүхтэй бөгөөд шүтээн зураг урлаачид нь урлахуйн ухаанд мэргэшиж, бүтээх гэж буй бурхдынхаа авшгийг хүртэж, эрх авдаг уламжлалтай. Тиймээс арван хангал буюу арван өөр бурхныг нэгэн ижил өнгө зохирлоор, цувуулан бүтээсэн нь нэн ховор байдаг гэж судлаачид тэмдэглэсэн байдаг. Мөн бурхан урлаачид нь өөрийн бүтээж буй бурхдыг шүтээн хэмээн сэтгэж</td><td>Дэмжсэн</td></tr>
<tr><td>2</td><td>Очирваань</td><td>Г.42.114</td><td>1</td><td>Урт-92см,<br>Өргөн-65см<br>Хүрээ торго:<br>Урт-176 см<br>Өргөн-92см</td><td>1119ЧЛМ 00266</td><td>Дэмжсэн</td></tr>
<tr><td>3</td><td>Гомбо</td><td>Г.42.115</td><td>1</td><td>Урт-92см,<br>Өргөн-65см<br>Хүрээ торго:<br>Урт-178 см<br>Өргөн-92см</td><td>1119ЧЛМ 00267</td><td>Дэмжсэн</td></tr>
<tr><td>4</td><td>Гонгор</td><td>Г.42.116</td><td>1</td><td>Урт-92см,<br>Өргөн-65см<br>Хүрээ торго:<br>Урт-180 см<br>Өргөн-92см</td><td>1119ЧЛМ 00268</td><td>Дэмжсэн</td></tr>
<tr><td>5</td><td>Чойжоо</td><td>Г.42.117</td><td>1</td><td>Урт-92см,<br>Өргөн-65см<br>Хүрээ торго:<br>Урт-176 см<br>Өргөн-92см</td><td>1119ЧЛМ 00269</td><td>Дэмжсэн</td></tr>
<tr><td>6</td><td>Лхам</td><td>Г.42.118</td><td>1</td><td>Урт-92см,<br>Өргөн-65см<br>Хүрээ торго:<br>Урт-177 см<br>Өргөн-92см</td><td>1119ЧЛМ 00270</td><td>Дэмжсэн</td></tr>
<tr><td>7</td><td>Шалш</td><td>Г.42.119</td><td>1</td><td>Урт-92см,<br>Өргөн-65см</td><td>1119ЧЛМ 00271</td><td>Дэмжсэн</td></tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрээ торго:<br>Урт-176 см<br>Өргөн-92см | | дахь Ази, Номхон далайн музей, 2020 он<br>- “Шүтээн зураг” цахим үзэсгэлэн, 2022 он.<br>- “Мандал” гэрэл зургийн үзэсгэлэн, УБ, Гадаад харилцааны яамны Номин танхим, 2023 он.<br>- “Шүтээн зураг” цаг тооны бичиг, 2023 он. | | |
| 8 | Намсрай | Г.42.120 | 1 | Урт-92см,<br>Өргөн-65см<br>Хүрээ торго:<br>Урт-179 см<br>Өргөн-92см | 1119ЧЛМ 00272 | | бүтээдэг асан учир бүтээсэн бурхныхаа буюу шүтээн зургийнхаа ард “донтор” буюу хаяг, тайлбар бичиж үлдээсэн нь нэн ховор байдаг. Чойжин ламын сүм музейд хадгалагдаж буй эдгээр арван хангалын шүтээн зургийн ард, тусгай даавуу дээр, төвөдөөр бичиж үлдээсэн байдаг.<br>Урлахуйн дэг, утга бэлгэдэл, өнгө будгийн нарийн зохироонд бүтээсэн энэхүү шүтээн зургийг Монгол төрийн их чойжин, Эрдэнэ билигт, Тунгалаг бишрэлт хутагт Лувсанхайдав (1872-1918) тусгайлан бүтээлгэж, тахиж байжээ.<br>Г.42.113 хувийн дугаартай “Жигжид” буюу Ямандаг бурхныг тод үндсэн өнгөөр, түүнийг тойрсон бусад нөхөд сэлтийг болон дэвсгэр хэсгийг зөөлөн өнгөөр шийджээ.<br>Г.42.119 хувийн дугаартай “Шалш” буюу Дөрвөн Нигуурт Гомбо бурхны нэрийг төвөдөөр “Шал-ши” гэх бөгөөд энэ нь “Дөрвөн нүүрт” гэсэн утгатай юм. Дөрвөн нигуурт Гомбо нь Нууцын хураангуйн үндэс, дандрын ёсны ядам бурхан, “шашин номын сахиус” юм. Дайсны хүч чадлыг булаагч Шалши нь нууц утгадаа Гомбо бурхантай нэгэн мөн чанартай хэмээн үздэг. Дөрвөн нигуурт Гомбо бурхны шид бүтээлийн, үйлс зохионгуйн, дөрвөн | Дэмжсэн |
| 9 | Жамсран | Г.42.121 | 1 | Урт-92см,<br>Өргөн-65см<br>Хүрээ торго:<br>Урт-178 см<br>Өргөн-92см | 1119ЧЛМ 00732 | | | Дэмжсэн |
| 10 | Цамба | Г.42.122 | 1 | Урт-92см,<br>Өргөн-65см<br>Хүрээ торго:<br>Урт-176 см<br>Өргөн-92см | 1119ЧЛМ 00274 | | | Дэмжсэн |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | язгуурын, Чөтгөр тэргүүнт гэх тэргүүтэн тус бүрдээ<br>харилцан адилгүй ялимгүй өөр өөр өнгө төрх, бэлгэдэл бүхий олон дүр байдаг юм. Монголын нэрт шүтээн урлаач Балжинням гэлэнгийн энэхүү бүтээл бол шид бүтээлийн Дөрвөн нигуурт Гомбо мөн.<br>Бурхан дүрслэлийн тигийг хатуу баримтлан бүтээсэн монгол шүтээн зургийн сонгодог төлөөлөл болох эдгээр арван хангалыг Төвөдийн шүтээн зургуудаас ялгаатайгаар арын газар орныг зөвхөн ногоон зүлэг, гол ус, наран хийгээд саран бээр гийгүүлсэн гүн хөх тэнгэр бүхий дүрслэлтэй урласан байна.<br>Монголын шүтээн зураг урлаачдын нэгэн шилдэг төлөөлөгч Балжинням гэлэнгийн энэхүү бүтээл бол XIX-XX зууны үеийн Монгол шүтээн зураг урлалын эдгээр сор бүтээл нь Эрдэнэ билигт, тунгалаг бишрэлт Лувсанхайдав хутагтын сахиусны буулт, ард олны сүсэг бишрэлийн их хүч шингэсэн түүх, шашин, соёл, урлагийн хосгүй үнэт өв мөн. | |
| **10 ДЭСИЙН 10 ШИРХЭГ** | | | | | | | | | |